



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 5/М.

Ховд

Л.Цэдэн-Ишийг ажилд томилох тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар “Улс төрийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэх тогтоох тухай” тогтоолын 1 дэх заалт, Дөргөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 05/1504 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Лхамсүрэнгийн Цэдэн-Ишийг 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн Дөргөн сумын Засаг даргаар томилсугай.

2.Л.Цэдэн-Ишд Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын “Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох” 11 дүгээр хавсралтын дагуу 979762 төгрөг /есөн зуун далан есөн мянга долоон зуун жаран хоёр/-өөр цалинжуулж, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тооцон сар бүр олгохыг Дөргөн сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Б.Бадамгарав/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Л.Цэдэн-Ишд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax B/14 Ch
02 0557